

19.6. Багшийн мэдээлэл импортлох

Багшийн мэдээллийг excel файл дээр бэлдэж татах боломжтой. Импортлох excel – файлын загвар нь системийн **Дата импорт -> Багш -> Загвар татах -> InstructorImportTemplate.xlsx** гэсэн нэртэй файл байна.

Өмнөх нөхцөл

- Сургалтын байгууллага идэвхтэй төлөвтэй байна.
- Салбар, бүрэлдэхүүн сургууль үүссэн байх, төлөв нь идэвхтэй байх.
- Сургалтын нэгж үүссэн байх, төлөв нь идэвхтэй байх.
- Багшийг эхлээд ажилтнаар бүртгэсэн байх.

Зөвлөмж

- Тоо төрлийн талбарт зөвхөн тоон утга оруулна.
- Огноо төрлийн талбарт он-сар-өдөр форматаар оруулна.
- Текст төрлийн талбарт тоо, үсэг, тэмдэгтээс бүрдсэн мэдээлэл оруулна.
- Ганц сонголт талбарт өгөгдсөн ангиллаас нэгийг сонгоно.
- Заавал бөглөх талбарын өгөгдлийг оруулсан байх.
- Тухайн мэдээлэл дэх код, нэрийг давхцуулахгүйгээр оруулах

Файлын баганын мэдээлэл

Баганы нэр	Төрөл	Тайлбар	Заавал бөглөх талбар эсэх
Сургалтын байгууллагын код	Текст	Сургалтын байгууллагын кодыг оруулна. Энэ нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд сургалтын байгуулылагыг давхцахгүй байдлаар кодолсон код юм. Систем тухайн кодоор сургалтын байгууллагыг танина. Код буруу оруулсан	Заавал

		тохиолдолд алдаа заана.ы Сургалтын байгууллагын кодыг Систем > Манай байгууллага > Ерөнхий мэдээлэл таб > Үндсэн мэдээлэл хэсэг > Код талбараас харна уу!	
Хүний иргэншил	Ганц сонголт	Иргэншлийн төрлийг сонгоно.	Заавал
Хүний регистрийн дугаар	Текст	Регистрийн дугаарын мэдээллийг оруулна. Хэрэв гадаад багш бол бүртгэлийн дугаарыг оруулна.	Заавал
Эцэг/эхийн нэр	Текст	Эцэг/эхийн нэрийг оруулна.	Заавал
Нэр	Текст	Багшийн нэрийг оруулна.	Заавал
Багшийн төрөл	Ганц сонголт	Багшийн албан тушаалын тохирох төрлийг сонгоно. Үүнд: • Дадлагажигч багш • Багш • Ахлах багш • Дэд профессор багш • Профессор багш	Заавал
Багшийн код	Текст	Багшийн кодыг давхцахгүй байдлаар оруулна. Энэ нь сургалтын байгууллагын багшийг хооронд нь ялгах, таних зорилгоор өгсөн давхцахгүй код байна.	Заавал
Багшийн ачаалал	Ганц сонголт	Багшийн ачааллын ытохирох төрлийг сонгоно.	Заавал
Ажлын харилцаа	Ганц сонголт	Багшийн ажлын харилцааны тохирох төрлийг сонгоно.	Заавал
Зөвлөх багш эсэх	Ганц сонголт	Багш нь зөвлөх эсвэл димплогын ажлын удирдагч багш бол тийм гэж тэмдэглэнэ. Энэ талбарт тийм гэж сонгосон багшийн нэр суралцагч бүртгэхэд Зөвлөх/Удирдагч багш талбарын жагсаалтад харагдана.	Заавал
Салбар, бүрэлдэхүүн сургуулийн код	Текст	Багшийн хувьд аль салбар, бүрэлдэхүүн сургуульд харъяалагдахыг тохируулна. Салбар,	Заавал

		бүрэлдэхүүн сургуулийн кодыг Систем > Манай байгууллага > Салбар, бүрэлдэхүүн сургууль хэсгээс харна уу!	
Үндсэн сургалтын нэгжийн код	Текст	Багшийн харъяалагдах тэнхим, профессорын баг зэрэг үндсэн харъяалагдах нэгжийг тохируулна. Сургалтын нэгжийн кодыг Систем > Манай байгууллага > Сургалтын нэгж таб > Код талбараас харна уу!	Заавал